



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/33


Өвт

Газар зүйн нэрийн салбар зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Геодези зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2, 5.8.4, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай” 2017 оны 186 дугаар зарлиг, Улсын Их Хурлын “Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” 2003 оны 40 дүгээр тогтоол, Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газрын даргын “Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн дүрэм батлах тухай” 2019 оны А/290 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын “Газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулах тухай” 2019 оны А/187 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг хавсралтаар баталсугай.
2. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх ажлыг зохион байгуулах, газарзүйн нэрийг мэдээллийн санд бүрдүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах, шинээр өгөх болон өөрчлөх газар зүйн нэрийг хэлэлцэн “Аймгийн газар зүйн нэрийн салбар зөвлөл”-д хүргүүлэхийг сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Газрын даамал (И.Маралмаа)-д даалгасугай.
3. Газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах, дээрх ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт суулгах, тухай бүр шинэчлэн ажиллахыг сумын газар зүйн нэрийн салбар зөвлөлийн дарга (Н.Бат-Эрдэнэ), Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.
4. “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг шинэчлэн байгуулах ажилтай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн “Газар зүйн зөвлөл байгуулах тухай” А/72 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН



622101067

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

Сумын Засаг даргын 2022 оны 03 дүгээр
сарын 09-ны өдрийн 1/2 дугаар
захирамжийн хавсралт



СУМЫН ГАЗАРЗҮЙН НЭРИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг Даргын Тамгийн Газрын дарга)

Нарийн бичгийн дарга: И.Маралмаа (Газрын даамал)

Гишүүд : О.Отгонтуяа (Санхүүгийн албаны дарга)

Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Х.Чулуунбат (Тусгай хамгаалалттай газрын хэсгийн дарга)

Э.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад)

Багийн Засаг дарга нар

Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нар

Т.Дондогсэрчин (Ахмадын хорооны дарга)